

БАТЛАВ
ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ДУР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.НАРМАНДАХ

2026 оны 03 дугаар сарын 10

ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 оны 03 дугаар сарын 10

Дугаар 03

Орхон аймаг

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН АВЛИГА, АШИГ СОНИРХОЛ, ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Ёс зүйн зөрчилд өртөх, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэргийн эрсдэлийг тодорхойлох үнэлэх ажлын хүрээнд:					
Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хүрэх түвшин	Хариуцах нэгж албан тушаалтан
1.	Авилга албан тушаалын гэмт хэрэгт холбогдох, ёс зүйн зөрчилдөртөх, албан тушаалын эрх мэдэлээ урвуулан ашиглах эрсдэл үүсэж болзошгүй үйл ажиллагааны болон албан тушаалын жагсаалтыг гаргаж тодорхойлох	Жагсаалт гаргасан эсэх	II улирал	Албан тушаалтны жагсаалтыг гаргаж тодорхойлсон байна.	Авлигын эсрэг стандартын комисс, Ёс зүйн дэд хороо
2. Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд:					
1.	Авлига ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, ёс зүйн дүрэм журмыг тогтмол сурталчлан таниулах мөрдүүлэх	Арга хэмжээний тоо	I-IV улирал	Авлига ашиг сонирхол, ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.	Авлигын эсрэг стандартын комисс, Ёс зүйн дэд хороо

2.	Шинээр томилогдсон албан хаагчдад холбогдох хууль журмыг танилцуулах, тэдгээрийг сургалтад хамруулах	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо, сургалтын чанар үр дүн	II, IV улирал	Шинээр томилогдсон албан хаагчдыг 2-оос доошгүй удаагийн сургалтад хамруулсан байна.	Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
3.	Албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчил, албан тушаалын гэмт хэргийн хор уршгийн талаар болон ёс зүй, сахилга, хариуцлагын талаарх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах,	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	I-IV улирал	Мэргэжлийн байгууллагуудтай хамтран 2-оос доошгүй сургалтад албан хаагчдыг хамруулсан байна.	Авлигын эсрэг стандартын комисс, Ёс зүйн дэд хороо
4	Авлигын эсрэг хууль тогтоомж, ёс зүйн хэм хэмжээг сурталчилсан гарын авлага, санамж, мэдээллийг бэлтгэн цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан сурталчлах	Байршуулсан мэдээллийн тоо, цахимаар түгээсэн мэдээ мэдээллийн тоо, хандалтын тоо	I-IV улирал	Гарын авлага санамж бэлтгэсэн байна. Сард 1 -ээс доошгүй пост, мэдээ мэдээлэл бэлтгэн олон нийтэд түгээсэн байна.	Авлигын эсрэг стандартын комисс, Ёс зүйн дэд хороо
5	Байгууллагын дотоод журамд шүгэл үлээгчийг хамгаалах, хамгаалалтын арга хэмжээг тусгах;	Дотоод журамд тусгасан байна.	II улирал	Дотоод журамд тусгасаж мөрдөж ажилласан байна.	Хүний нөөц, хуулийн мэргэжилтэн
6	Ёс зүй, шударга байдлыг дэмжих эрсдэлийг бууруулах дотоод зөвлөмжийг бэлтгэх, түгээх	Зөвлөмж бэлтгэн түгээсэн байна.	III улирал	Зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна.	Ёс зүйн дэд хороо
3. Хууль, тогтоомж болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:					
3.1	Нийгмийн даатгалын тухай хууль, холбогдох журам, зааврын хэрэгжилтэд		I-IV улирал	Нийгмийн даатгалын тухай хууль, холбогдох журам, зааврын	Захиргаа хяналтын хэлтэс

	эрсдэлд суурилсан дотоод хяналт, шалгалтыг тогтмол зохион байгуулах, алдаа зөрчлийг арилгах хэрэгжилтэд хяналт тавих	Хяналт шалгалтын тоо, Алдаа зөрчлийн тоо		хэрэгжилтэд сайжирсан байна. Алдаа зөрчлийн тоо буурсан байна.	
3.2	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй холбоотой шийдвэр гаргах үйл ажиллагаанд хууль эрх зүйн үндэслэлийг оновчтой тодорхойлох, дотоод хяналтыг сайжруулж, хууль зөрчсөн шийдвэр гаргах эрсдэлээс сэргийлэх	Удирдах албан тушаалтнууд харъяалах албан хаагчдын шийдвэр гаргах үйл ажиллагаанд хяналт тавиж хууль зөрчиж гаргахгүй байх	I-IV улирал	Хууль зөрчиж гаргасан шийдвэр гаргалт 0 байна.	Нэгжийн дарга нар
4. Дотоод үйл ажиллагааг сайжруулах, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх хүрээнд					
4.1	Хуулиар тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн тухай гомдол, мэдээлэл хүлээн авах, эрх бүхий байгууллагад мэдээлэх, хүргүүлэх ажлыг зохион байгуулж эрх бүхий албан тушаалтанд хариуцуулан ажиллуулах, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох байгууллагад шилжүүлэх	Мэдээлэл гомдлыг хүлээн авч, эрх бүхий байгууллагад мэдээлсэн байна.	I-IV улирал	Гомдол мэдээллийг цаг тухай бүрт хүлээн авч шийдвэрлэсэн байна.	Ёс зүйн дэд хороо ЭБАТ
4.2	Нийгмийн даатгалын газрын хяналтын камерын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах, сайжруулах, ажиллагаанд нь тогтмол хяналт тавих;	Сайжруулах арга хэмжээ авсан эсэх, хяналт хийсэн тоо	I-IV улирал	Хяналтын камерны үйл ажиллагааны сайжирсан байна. Хэвийн ажиллагаанд сар	Мэдээллийн технологийн ажилтан

				бүр тогтмол хяналт хийж ажилласан байна.	
4.3	Иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээний шат дараалал, шаардлагатай баримт бичиг, хугацаа, шаардлагыг ил тод мэдээлж мэдээллийг ойлгомжтой байдлаар түгээх;	Авсан арга хэмжээ, түгээсэн мэдээ мэдээллийн тоо, чанар	I-IV улирал	Нийгмийн даатгалын үйл ажиллагаа сайжирсан байна.	Сургалт сурталчилгааны мэргэжилтэн
4.4	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах, ёс зүй, авлига, албан тушаал, ашиг сонирхлын зөрчил үйлдэх эрсдэлээс сэргийлэх, ёс зүйн зөрчил гаргасан хэрэгт дүн шинжилгээ хийн цаашид давтан гаргуулахгүй байх талаар тодорхой үйл ажиллагаа, арга хэмжээг зохион байгуулж хэвших	Арга хэмжээний тоо, чанар, үр дүн	I-IV улирал	Ёс зүйн зөрчлийн тоо буурсан байна. Дүн шинжилгээ хийсэн байна. 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	Ёс зүйн дэд хороо
4.5	Иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай, ил тод шийдвэрлэх, хуульд зааснаар хариу өгөх, бүртгэл хөтлөх, дүн шинжилгээ хийх, эрсдэлтэй үйл ажиллагааг тодорхойлон сайжруулах	Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн болон хугацаандаа шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо, дүн шинжилгээ хийсэн эсэх,	I-IV улирал	Иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж хэвшсэн байна. Дүн шинжилгээ хийж, эрсдэлтэй үйл ажиллагааг тодорхойлж сайжруулсан байна.	Албан хаагчид
4.6	Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан	ЭММЗ-ийн эмч мэргэжилтэнүүд 2-оос доошгүй	I-IV улирал	ЭММ-ийн эмч мэргэжилтэнүүд Авлига ашиг	ЭММЗ-ийн дарга, Магадлагч эмч

	танилцуулах, ЭММЗ-ийн гишүүдийг Авилга ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулах	удаагийн сургалтад хамрагдсан байна.		сонирхолын зөрчилгүй ажилласан байна.	
5. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг сайжруулах					
5.1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих	Нээлттэй мэдээллийн үнэлгээний хувь	I-IV улирал	Хуульд заасан нээлттэй мэдээллүүдийг бүрэн байршуулж, шинэчилж ажилласан байна.	Нэгжийн дарга нар
5.2	Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад гарсан аливаа хууль бус үйлдэл, зөрчил, авлига ашиг сонирхолын талаарх мэдээллийг холбогдох байгууллага албан тушаалтанд мэдээллэх	Мэдээллийн тоо	I-IV улирал	Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад аливаа хууль бус үйлдэл, зөрчилгүй гараагүй байна. Гарах шалтгаан нөхцөл буурсан байна.	Бүх тасаг нэгжийн дарга нар, албан хаагчид
5.3	Нийгмийн даатгалын байгууллага болон хувийн хэвшлийн байгууллага хооронд болон ажилтан албан хаагчидтай байгуулж буй аливаа гэрээ хэлэлцээрт авлига ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх талаар зохицуулалт тусгах	Бүх төрлийн гэрээ хэлэлцээрийн заалт тусгасан эсэх	Тухай бүр	Гэрээ хэлэлцээр байгуулагч талууд авлига ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Хүний нөөц, хуулийн мэргэжилтэн
5.4	Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл, Ёс зүйн дэд хороо, ЭММЗ-д ирсэн өргөдөл гомдол мэдээлэл, маргаан таслах үйл ажиллагааг сайжруулах, өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх	Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо, Шийдвэрлэсэн хугацаа	Тухай бүр	Маргаан таслах үйл ажиллагаа сайжирч өргөдөл хүсэлтийг шийдвэрлэх хугацаа буурсан байна.	МХШЗ-ийн дарга ЁЗДХ-ны дарга ЭММЗ-ийн дарга

6. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгах үйл ажиллагааны хүрээнд:					
6.1	Цахимаар үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, иргэд олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх	Цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо Цахим үйлчилгээний талаар иргэд олон нийтээс санал асуулга, судалгаа авсан дүн	I-IV улирал	Төрийн байгууллагын үйл ажиллагааны чанар хүртээмж дээшилсэн байна.	Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс, Хамралт орлогын хэлтэс
6.2	Нийтийн албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авах, Шинээр томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг хянуулсаны дараа томилох	- ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлсэн эсэх - ХАСУМ хянуулсны дараа томилж хэвшсэн байдал	Тухай бүр	Төрийн албан хаагчийн үйл ажиллагаа хуулийн дагуу явагдсан байна.	Эрх бүхий албан тушаалтан

ТАНИЛЦСАН:

ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРМАНДАХ

ЗАХИРГАА ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Г.ГАЛБАДРАХ

ХАМРАЛТ, ОРЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.БУЯНБАЯР

САНХҮҮ, БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ү.МЯГМАРСҮРЭН

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН
БАЙЦААГЧ, МЭРГЭЖИЛТЭН

Н.ХУЛАН

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

М.ДҮҮРЭНЖАРГАЛ

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЖИЛТАН

Ж.ХАЛИУНАА

МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧИГ

МАГАДЛАГЧ ЭМЧ

СТАНДАРТ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН БАГИЙН
НАРИЙН БИЧИГ

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ХҮНИЙ НӨӨЦ, ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.МИЧИДМАА

Б.ПҮРВЭЭ

Д.ЛХАГВАДУЛАМ

Д.ИДЭРЖАВХЛАН